

Батлав. БОАЖЯ – Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга

..... / А. Энхбат /

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн: “Тахилт хайрхан транс” ХХК-ийн гүйцэтгэх захирал

..... / Лай Жэнь Бао /

**“ТАХИЛТ ХАЙРХАН ТРАНС ХХК-ийн ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ
СУМЫН ЦАГААН-ОВОО БАГИЙН НУТАГТ БАЙРЛАХ “АЖИЛЧДЫН ХОТХОН,
АВТОБААЗ ТӨСӨЛ”-ийн 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР - 6284655/

Хянасан:

БОАЖЯ-Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын ахлах мэргэжилтэн

..... / П. Шинэцэцэг /

Боловсруулсан:

“Тахилт хайрхан транс” ХХК-ийн байгаль орчны ахлах мэргэжилтэн

..... / Б. Лхагважаргал /

2023 он



TAKHILT KHAIRKHAN TRANS
LLC

ТАХИЛТ ХАЙРХАН ТРАНС ХХК

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо,

Их Монгол Улсын гудамж,

Моннис Бьюлдинг, 6-р давхар

Утас: + (976) 88109158

Email: admin@tkl.mn

2023.06.26 № 23/202
танай _____ ны № _____ д

БОАЖА – ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИН,
БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН
УДИРДЛАГЫН ГАЗАРТ

Төлөвлөгөө батлуулах тухай

Манай компани Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Цагаан-овоо багийн нутаг дэвсгэрт 15 га талбайд 100 ширхэг хүнд даацын автомашины зогсоол, 400 ажилчдыг байршуулах хүчин чадалтай кемп, дэд бүтцийн төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

2020 оны 11-р сарын 06-ны өдрийн 2020/Т-094 дугаар бүхий төслийн Байгаль орчны нарийвчилсан байдлын үнэлгээ, Өмнөговь аймгийн БОАЖГ-ын 2023 оны 04-р сарын 04-ний өдрийн зөвлөмж, чиглэлүүд болон БОАЖА-ны сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот бүхий журмын дагуу боловсруулсан 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хүргүүлж байна.


Иймд 2023 оны байгаль орчны менежмент төлөвлөгөөг хянан батлаж, бидний ажилд дэмжлэг үзүүлнэ үү.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

赖真宝

ЛАЙ ЖЭНЬБАО



Батлав. БОАЖЯ – Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга
..... / А. Энхбат /

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн: “Тахилт хайрхан транс” ХХК-ийн гүйцэтгэх
захирал

..... / Лай Жэнь Бао /

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ СУМЫН ЦАГААН-ОВОО БАГИЙН
НУТАГ ДЭВСГЭРТ ОРШИХ “АЖИЛЧДЫН ХОТХОН, АВТОБААЗ”ТӨСЛИЙН
2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР - 6284655/

Хянасан:

БОАЖЯ-Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын ахлах
мэргэжилтэн

..... / П. Шинэцэцэг /

Боловсруулсан:

“Тахилт хайрхан транс” ХХК-ийн байгаль орчны ахлах мэргэжилтэн

..... / Б. Лхагважаргал /

2023 он

АГУУЛГА

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
1.1 Төслийн хүчин чадал:	2
ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙД БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	4
2.1 Төсөл хэрэгжих газар нутгийн хөрсөн бүрхэвч:	4
2.2 Төслийн талбай орчмын тоосжилт, агаарын чанарын, уур амьсгалын тухай	4
2.3 Төсөл хэрэгжих нутгийн ус	4
2.4 Төсөл хэрэгжих нутгин ургамалжилт	5
2.5 Төслийн талбайн амьтны аймаг	5
2.6 Нийгэм, эдийн засгийн байдал	6
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	7
3.1 Байгаль экосистемийн өөрчлөлт	7
3.2 Байгалийн баялаг, нөөц ашиглалт	7
3.3 Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, тусгай хамгаалалттай газар нутаг, археологи палентологийн олдвор	7
ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	11
ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ	12
ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	15
ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	15
НАЙМ. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	16
ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	18
АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	20
АРВАННЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	21
АРВАНХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	23
АРВАНГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ТӨСӨВ	23

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА


Тээврийн ажилчдын хотхон, автобаазын зориулалтаар үйл ажиллагаа явуулахаар баригдаж байгаа төсөл юм. Төсөл хэрэгжих талбай нь Өмнөговь аймгийн төвөөс 98км, Улаанбаатар хотоос 542 км зайтай орших Цогтцэций сумаас урагш 7,5км зайд Цагаан-овоо сумын нутаг дэвсгэрт хэрэгжинэ.

1.1 Төслийн хүчин чадал: ”Тавантолгой-Манлай-Ханги“ чиглэлийн нүүрс тээврийн Тавантолгой талаасаа 17 км зайд байрших бөгөөд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Цагаан-овоо багийн нутаг дэвсгэрт 15 га талбайд үйл ажиллагаа явуулна. Төсөл нь 100 ш хүнд даацын автомашины зогсоол, нэг дор 400 ажилчдыг байршуулах хүчин чадалтай ажилчдын кемп байгуулж үйл ажиллагааг явуулахаар төлөвлөсөн.



Зураг 1.1 Ажилчдын амьдарч буй түр байр

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Цагаан-Овоо багийн нутаг дэвсгэрт орших
“Ажилчдын хотхон-автобааз” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн
төлөвлөгөө



Зураг 1.2 Кемпийн төлөвлөлтийн план зураг

ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙД БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1 Төсөл хэрэгжих газар нутгийн хөрсөн бүрхэвч:

Төслийн хэрэгжих газрын хөрсөн бүрхэвчинд 3 цэгт 30 см-н зүсэлт хийж тодорхойлоход рН-8,4-8,5 давсжилт 0,04-0,08% ялзмаг 68%-г элсэнцэр, 15,2%-г элс, 13,3%-г хөнгөн шавранцар 3,5%-г дунд шавранцар хөрс тархан бүрдүүлж байна. Тус бүс нутагт хээржүү цөлийн цайвар бор хөрсний шинжийг агуулсан хөрс зонхилох ба ургамлын үндэс бага байгалийн үржил шим ядмагдуу. Төслийн талбайд хар тугалга болон хүнд металлын шинжилгээ хийхэд стандартаас давсан үзүүлэлт үгүй боловч бүс нутгийн онцлогоос хамаарч арсеник их гарах хандлагатай шинжлэгдсэн.

2.2 Төслийн талбай орчмын тоосжилт, агаарын чанарын, уур амьсгалын тухай

Төсөл хэрэгжих талбай орчмын агаарын температурын жилийн хэлбэлзлийн үнэмлэхүй 77°C байна. Үнэмлэхүй их температур 40°C , үнэмлэхүй бага температур -30°C байх ба сумын хаврын цочир хүйтрэлт дунджаар 5-р сарын 5-ны үед намрын цочир хүйтрэл 9 сарын сүүлчээр ажиглагддаг байна. Тус бүс нутагт 189-192 хоногт хүйтэн байх ба хавар зуны улиралд халуун салхитай шороон шуурга ихтэй байх ба хуурай болон хагас хуурай цаг агаар зонхилно.

Агаарын чанарын хувьд Цогтцэций сумын Цаг уурын харуулын ажиглалтын мэдээнээс харахад хавар зуны саруудад зөвшөөрөгдөх түвшнээс хоёр дахин, түүнээс илүү ч хэтэрсэн тохиолдлуудтай. Цогтцэций сум нь Тавантолгой, Эрдэнэставантолгой, Энержиресурс гэх мэт нүүрсний ил уурхайнуудын үйл ажиллагаа болон нүүрс тээврийн процесс тасралтгүй явагдаж байх тул агаар цацагдаж буй тоосжилт салхины нөлөөгөөр хурдан замхран алга болох боловч унах тоосжилтын хэмжээ өндөр байх боломжтой юм. Гэвч яг иж бүрэн судалгаагаар судлаж тогтоогоогүй байгаа. Агаарын чийгшил дунджаар 6,3-17,1 хувьтай. Агаарын бусад хийн найрлага тухайлбал хүхрийн хүчил, азотын давхар исэл зэрэг үзүүлэлтүүд стандартаас хэтрээгүй байна.

2.3 Төсөл хэрэгжих нутгийн ус

Усан хангамжийн хувьд Төв азийн гадагш урсгалгүй ай савд багтдаг. 2006 оны тооллогоор Улаан нуур, Шаазангийн нуур, Хангийн улаан нуур зэрэг цөөн хэдэн нуур арваад 10 булаг, цөөрөм тоологдсон. Тус бүс нутгийн 64% буюу 465,6 мян.га нь газрын доорхи усны нөөц бага ангилалд ордог. Тус бүс нутагт 2011 оны уст цэгийн тооллогоор инженерийн хийцтэй

өрөмдмөл худаг 32, богино яндант худаг 13, энгийн уурхайн худаг 155 нийт 200 бэлчээрийн худаг байна.

Төсөл хэрэгжих талбай орчимд бол гадаргын усгүй. Тус бүс нутгийн гидрогеологийн товч мэдээллийг төслийн БОТБҮ-ний 47-50-р хуудас унших боломжтой. Төслийн талбайн усны физик химийн шинж чанарын дүгнэлтээс дурдахад химийн бүрэлдэхүүнээрээ хлорын ангийн натри, калийн бүлгийн 2-р төрлийн чанарын хувьд цэнгэгдүү буюу харьцангуй ихэвтэр эрдэсжилттэй хатуу ус байна.

2.4 Төсөл хэрэгжих нутгийн ургамалжилт

Төслийн хэрэгжих бүсэд БОНБНҮ-ээр 36 бүст зүйлийн бичиглэл хийхэд нийт 128 зүйл ургамал бүртгэгдсэн ба ургамал газарзүйн мужлалаараа Цогтцэций сумын нутаг Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт багтана. Их шанхын нуруугаар Монгол өвс-ерхөг харганат, Цэций ууланд Монгол өвс боролзойт, шар бударганы толгодоор Баглуур-Монгол өвст, Цагаан овоотын талаар Монгол өвст таанат, Төхөмийн хөндийгөөр Таана тэсэгт, Таана боролзойт хармагтай, Хэгэс хавиргын талаар, Өнчийн тал, Цагаан товогийн тал, Бутат хоолой, Хүжитийн талаар Хотирт, бударгана баглуурт, хармагтай хэвшил зонхилно. Ургамалжилынхаа хувьд ургамлан нөмрөгийн тусгаг бүрхэц 14.2-30.6%, халцгай газар 10.6-60.6% эзэлж, ургац 1.1-1.81ц/га болсон байна.

Цогтцэций сумын нутагт ургаж байгаа 128 зүйл ургамлыг амьдралын хэлбэрээр ялгахад 33 зүйл нэг ба хоёр наст өвслөг ургамал, /26%/ 75 зүйл олон наст ургамал, /44%/ 35 зүйл сөөг сөөгөнцөр ургамал, 2 зүйл шарилж шимэгч ургамал/2%/ 2 зүйл модлог ургамал /2%/ бүртгэгдсэн болно.

2.5 Төслийн талбайн амьтны аймаг

Төслийн талбай орчим нь амьтны газарзүйн мужлалаар уулархаг азийн дэд их муж, говийн дэд мужийн хойт говийн тойрогт хамаардаг. Энэ нутагт 11 баг, 21 овог, 48 төрөлд хамаарагдах 66 зүйл шувуу тэмдэглэгдсэн байна. Судалгааны олон жилийн мэдээллүүдийг хянан үзэхэд энд 7 баг, 14 овогт хамаарагдах 42 зүйл хөхтөн тохиолддог байна.

Тус суманд гадаргын ус байхгүй, нутгийн ихэнх хэсэг хуурайсаг, харин бороо хур элбэгтэй жилүүдэд Улаан нуур мэтийн шал хоолой дагаж задгайран ус тогтдог нь намар ба зундаа дайрч өнгөрөх ус хайн орж ирэх хэвлээр явагч хөхтөн болон шувуудын зүйлүүдэд нэн таатай нөхцөл бүрдүүлдэг. Хөхтөн шувуу мөлхөгчдийн гэх 3 ангид хамаарах 42 зүйлийн сээртэн

амьтад байна. Үүнээс 4 баг, 6 овог 11 төрөлд хамаарах 18 зүйлийн хөхтөн, 16 зүйл шувуу, 8 зүйл мөлхөгчид тархсан байна.

2.6 Нийгэм, эдийн засгийн байдал

Өмнөговь аймгийн Цогтцэций сум анх 1924 онд байгуулагдсан. Цогтцэций сум нь 72.5 хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэртэй, Алтайн уулархаг мужид багтдаг. Нийслэлээс 540 км, аймгийн төвөөс 100 км зайд, өөрийн аймгийн Цогт-Овоо, Манлай, Баян-Овоо, Ханхонгор, Ханбогд, Номгон сумдуудтай, Дундговь аймгийн Өлзийт сумтай хиллэн, далайн түвшинээс 1200-1791 м-ийн өндөрлөгт орших бөгөөд бүхэлдээ говь цөлийн бүсэд хамаарна.

Эрүүл мэнд: Төрөлт, нас баралт: 2022 оны эхний 8 сарын байдлаар аймгийн хэмжээгээр 775 эх амаржиж, 212 хүн нас барсан нь урьд оны мөн үеэс төрөлт 30,6 хувиар буурч, нас баралт 8,2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Цогтцэций сумын хэмжээнд 8 дугаар сарын байдлаар 96 эх амаржиж 18 хүн нас барсан нь урьд онтой харьцуулахад төрөлт 57.9 хувиар буурч, нас баралт мөн адил 10 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Эмнэлэгийн тусламж үйлчилгээ: Өмнөговь аймгийн Цогтцэций суманд үйл ажиллагаа явуулж буй эмнэлэгүүд нь 2022 оны 08 дугаар сарын байдлаар 15863 эмнэлэгийн тусламж үйлчилгээ үзүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 30.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хөдөлмөр эрхлэлт: 2022 оны эхний 8-р сарын байдлаар аймгийн хөдөлмөрийн захад бүртгэлтэй ажил идэвхтэй хайж байгаа 325 иргэн байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 200 хүнээр буюу 38 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Тайлант сард 147 хүн шинээр бүртгэгдэж, бүртгэлээс 165 хүн хасагдаж, 31 иргэн ажилд орсон байна. Үүнээс Цогтцэций сумын хэмжээнд хөдөлмөрийн захад бүртгэлтэй 6 иргэн байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад 33.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Нийгмийн даатгалын үйлчилгээ: Нийгмийн даатгалын сангийн орлого 2022 оны эхний 8 сард 53881,1 сая төгрөг төвлөрч, төлөвлөгөөний биелэлт 1247,4 хувьтай байна. Харин нийгмийн сайн дурын даатгуулагчийн тоо 3466 байгаа нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 13 хүнээр буюу 0,4 хувиар өссөн байна. Цогтцэций сумын хэмжээнд 2022 оны эхний 8 сард 263708.2 сая төгрөгийн орлого төвлөрч, төлөвлөгөөний биелэлт 108.6 хувьтай байна.

Хөдөө аж ахуй: Аймгийн хэмжээнд оны эхний 8 сарын байдлаар нийт 809218 мал төллөж, 811051 төл гарч, 422 төл мал хорогдож, 730766 төл мал бойжиж байна. Төл бойжилтыг сумдаар авч үзвэл Булган, Номгон, Мандал-овоо, Ханхонгор сумдад өндөр үзүүлэлттэй байна.

Цогтцэций сумын хэмжээнд эхний 8 сарын байдлаар нийт 72929 мал төллөж, 72929 төл гарч, 0 төл мал хорогдож, 72929 төл мал бойжиж байна.

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Тээврийн ажилчдын хотхон автобаазын БОНБНҮ-нд төслийн нөлөөллийг БОНХ-ийн Сайдын 2014 оны 4 сарын 10-ны өдрийн А-117 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачлал”-ийг баримтлан Магадлан жагсаах болон Леопольдын матрицын аргаар тодорхойлсон. Төслийн орон зайн хамрах хүрээ нь шууд болон шууд бус нөлөөллийн бүсээр тодорхойлогдоно. Шууд нөлөөллийн бүс нь 15 га бөгөөд энэ хүрээнд төслийн үйл ажиллагаа явагдаж байна.

3.1 Байгаль экосистемийн өөрчлөлт

Үйлдвэрийн зориулалтаар усыг ашиглахгүй, унд ахуйн зориулалтаар ашиглана. Усны нөөцөд харьцангуй нөлөөлөл багатай. Төслийн үйл ажиллагаагаар хүн, машин техникийн хөдөлгөөн ихсэх, нүүрсний нунтаг тоосонцор, автомашины шороон замын тээвэрлэлт зэргээс төслийн талбайд байгаль экосистемийн бүрэлдэхүүн хэсэг болох хөрс ургамалд шууд нөлөөлнө.

Энэ нь төслийн талбайн хөрсөн бүрхэвч ургамлан нөмрөг, барилга байгууламжид дарагдах, талбайн хөрс хүнд машин техникийн нөлөөгөөр дагтарших, ургамлан бүрхэвч талхлагдах, тухайн орчны өнгөн хөрс элэгдэл эвдрэлд орох зэрэг болно. Төсөл хэрэгжиж буй бүс нутаг нь хөрсний элэгдэл эвдрэл ихтэй маш хүчтэй цөлжсөн нутаг юм.

3.2 Байгалийн баялаг, нөөц ашиглалт

Тээврийн ажилчдын хотхон, автобааз төслийг хэрэгжүүлэхдээ үйлдвэрлэл, бүтээгдэхүүн, боловсруулалт хийхгүй учир төслийн технологид түүхий эдийн зориулалтаар байгалийн баялаг ашиглахгүй. Төсөл хэрэгжих талбайн орчим ой мод, ус намгархаг газар байхгүй. Ургамал, амьтны нөөцийг шууд ашиглахгүй тул биологийн олон янз байдалд нөлөөлөх нь бага байна.

3.3 Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, тусгай хамгаалалттай газар нутаг, археологи палентологийн олдвор

Төслийн талбай нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хэрэгжихгүй бөгөөд талбай орчимд түүх соёлын дурсгалт зүйл археологи, палентологийн ховор олдворын зүйл байхгүй учир төслийн үйл ажиллагаанаас нөлөөлөлгүй болно.

**Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Цагаан-Овоо багийн нутаг дэвсгэрт орших
“Ажилчдын хотхон-автобааз” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн
төлөвлөгөө**

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Цагаан овоо багийн нутагт хэрэгжүүлэхээр төлөвлөж буй “Тээврийн ажилчдын хотхон, авто бааз” төслийг хэрэгжүүлэхэд хүрээлэн буй орчинд учирч болзошгүй нөлөөллийг тодорхойлсон үр дүнд үндэслэн нөлөөллийн эх үүсвэр, шинж чанарыг тодорхойлж дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 3.1 Байгаль орчны бүрдэл хэсгүүдээр болзошгүй сөрөг нөлөөлөл ба эх үүсвэр

№	Нөлөөлөл	Нөлөөллийн эх үүсвэр (Үйл ажиллагаа)	Нөлөөллийн шинж чанар
Агаар орчин			
1	Тоосжилт (PM2.5, PM10)	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн	-
		Хөрс хуулалт	Тархах хүрээ хязгаарлагдмал
		Түр зам ашиглах	Салхины хурд бриксийн хурдаас давах, агаарын температур их үед үүснэ
		Карьер олборлох үед	Улирлын чанартай
2	Хийн хаягдал (Утаа Угаар, SO, NO, CO)	Тээврийн хэрэгсэл, машин механизмын хөдөлгүүр	Агаарыг бохирдуулах боловч хадгалагдах болон тархах хүрээ хязгаарлагдмал.
Усан орчин			
3	Усны нөөцийн хомсдол	Унд ахуйн усны хэрэглээ	Зөөврөөр хангана
4	Хатуу болон шингэн хаягдал	Бетон зуурмаг, зам талбайн усалгаанд ус ашиглах	Гадаргын ус бохирдох бусад эх үүсвэрүүд
		Ахуйн хатуу, шингэн хог хаягдал	Газрын доорх усны бохирдолд өртөгдөх байдал
			Удаан сарнина.
			Гадаргын хэлбэршил
Хөрсөн бүрхэвч			
5	Элэгдэл, эвдрэл	Хүний хөл хөдөлгөөнд байнга өртөж буй зам, талхлагдах	Хөрсний физик, механик шинж чанар өөрчлөлт орох
		Барилгын ажилд ашиглагдах элс, хайрганы карьерыг ашиглах	Тархалтыг хязгаарлах боломжтой. Барилгын ажлын дараа ашигласан карьер болон түр замыг нөхөн сэргээлтийг хийх тохиолдолд нөлөөлөл багасах боломжтой.

**Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Цагаан-Овоо багийн нутаг дэвсгэрт орших
“Ажилчдын хотхон-автобааз” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн
төлөвлөгөө**

6	Бохирдол	Машин техникийн хөдөлгөөнөөр олон салаа зам үүсэх	Тогтсон нэг замаар зорчих
		Түр зам үүсэх	Тархах хүрээ хязгаарлагдмал.
		Ахуйн хатуу, шингэн хог хаягдал	Хөрсний микробиологийн шинж чанар алдагдана
		Шатах тослох материалын алдагдал	Хөрсний бохирдол шингээх хурд
Ургамлан бүрхэвч			
7	Ургамлан нөмрөг талхлагдах	Ашиглалтын талбай	Хэмжээ хязгаарлагдмал.
			Ургамлын төрөлл зүйл устгах
			Ногоон байгууламж, тарималжуулалт хийснээр нөхөн сэргээх боломжтой.
Амьтан			
8	Үргэн дайжих	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн	Суурьшлын бүс
		Дуу чимээ	Тухайн орчинд амьдрах боломжгүй болж дайжих
		Хог хаягдал	Тархалтын хүрээ хязгаарлагдмал
9	Хордох	Машин, механизмаас шатах тослох материал асгаралт	Хөрсөн дэх бичил биетэн, шавж хорхой үрэгдэх
			Ашиггүй бичил биетэн үржих
Нийгэм-эдийн засгийн орчин			
10	Үндсэн хөрөнгө	Татварын эх үүсвэр	Улсын төсөвт хувь нэмэр оруулна
11	Шинэ ажиллагсад	Ажлын байр бий болно	Орон нутгийн иргэд орлогын тогтмол эх үүсвэртэй болно

**Хүснэгт 3.2 Байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа,
эрчмийн магадлал**

№	Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуула	Богино хугацааны	Дунд хугацааны	Урт хугацааны	Буцалттай	Буцалтгүй
Байгалийн экосистемийн өөрчлөлт									
1	Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл	Т	Ү	Ү	Т	Ү	Ү	Ү	Т
2	Төслийн үйл ажиллагаанаас ургамлын бүлгэмдэл үзүүлэх нөлөөлөл	Т	Ү	Ү	Ү	Т	Ү	Т	Ү
3	Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөл	Ү	Т	Ү	Т	Ү	Ү	Т	Ү
4	Геологийн тогтоцын өөрчлөлт	Ү	Ү	Т	Ү	Ү	Ү	Ү	Ү
Байгалийн нөөц ашиглалт									
5	Газрын гадаргын нөөц баялаг	Ү	Ү	Ү	Ү	Ү	Ү	Ү	Ү
6	Эрдэс түүхий эдийн нөөц	Ү	Ү	Ү	Ү	Ү	Ү	Ү	Ү
7	Эрчим хүчний нөөц	Т	Ү	Ү	Ү	Т	Ү	Ү	Т
Байгаль орчны чанарын өөрчлөлт									
8	Орчинд тоосжилт үүсэх	Ү	Т	Т	Т	Ү	Ү	Т	Ү
9	Уур амьсгалын бичил өөрчлөлт	Ү	Т	Ү	Ү	Т	Ү	Т	Ү
Байгалийн өнгө төрх, түүхт соёлын дурсгалт зүйл, палентологийн олзвор									
10	Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх	Ү	Ү	Ү	Ү	Ү	Ү	Ү	Ү
11	Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	Ү	Т	Ү	Ү	Ү	Ү	Ү	Ү
12	Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх	Ү	Ү	Ү	Ү	Ү	Ү	Ү	Ү
13	Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх	Ү	Ү	Ү	Ү	Ү	Ү	Ү	Ү
14	Археологи, палентологийн олдворт нөлөөлөх	Ү	Ү	Ү	Ү	Ү	Ү	Ү	Ү
Эдийн засаг, нийгмийн асуудал									
15	Орон нутгийн орлого нэмэгдэх	Т	Т	Ү	Ү	Ү	Т	Ү	Т
16	Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	Т	Т	Ү	Ү	Ү	Т	Ү	Т
17	Ажлын байр нэмэгдэх	Т	Ү	Ү	Ү	Т	Ү	Т	Ү
18	Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	Т	Ү	Ү	Ү	Ү	Ү	Т	Ү
19	Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх	Ү	Т	Ү	Ү	Т	Ү	Ү	Т
Бусад нөлөөлөл									
20	Ахуйн хатуу хог хаягдлын цэгийн ариутгал, халдваргүйжүүлэлт муугаас эвгүй үнэр гарах, шавж үржих	Ү	Т	Ү	Ү	Т	Ү	Т	Ү

ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Энэхүү төлөвлөгөө нь “Тахилт хайрхан транс” ХХК-ийн Өмнөговь аймгийн Цогтцэций сумын урд зүгт 7.5 км зайд орших “Тээврийн хотхон автобааз” төслийн 2023 оны кемпийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлөх нөлөөллийг багасгах, төслийн үйл ажиллагааны явцад байгаль орчны бүрдэл хэсгийн суурь судалгааг эмх цэгцтэй, менежменттэй, дэс дараатай хийж эхлүүлэх, байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх зорилготой юм.

Байгаль орчны бүрдэл хэсгийн суурь судалгаа дотоод мониторингийг хийснээр тэдгээрт гарах өөрчлөлтийг аль болох хурдан мэдэрч зохистой арга хэмжээг авах ач холбогдолтой.

Кемпийн үйл ажиллагааны улмаас хүн амын төвлөрөл ихсэх ба түүнээс гарах гол болон гарч болзошгүй сөрөг нөлөөллүүд тэдгээрийн үр дагавраас урьдчилан сэргийлэх, түүнийг багасгаж, бууруулах, замаар төслийг байгаль орчинд ээлтэйгээр хэрэгжүүлэх арга замыг багтаасан болно.

2023 онд Таван Толгой кемпийн үндсэн барилга байгууламжийн бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэх, болон бусад байгууламжуудыг байгуулна.

Мөн ажилчдын ая тухтай орон байр, хоол унд, засвар үйлчилгээ хийх нөхцөл боломжийг ханган ажиллана.

Байгаль орчинд сөргөөр нөлөөлөх нөлөөллийг бууруулах арга хэмжээ бүрт тавигдсан шаардлагын дагуу холбогдох зардлыг урьдчилан тооцоолж тусгав. Эдгээр зардал нь байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийх ажлын шууд зардал бөгөөд бусад урьдчилан тогтоох боломжгүй зардлыг тооцоогүй болно.

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

№	Гол болон болзошгүй нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал төгрөг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Агаар орчныг сөрөг нөлөөллөөс хамгаалах	Замын тоосжилтыг бууруулах зорилгоор усалгаа хийх (дулааны улиралд усалгааг тогтмол хийх)	Кемпийн хэмжээнд	Тн	-	12	-	3-9 сард	"Агаарын тухай" болон "Агаарын бохирдлын төлбөрийн тухай" хууль; MNS 4585:2016 "Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага" MNS 6063:2010 "Агаарын чанар, хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ"
2		Тоостой нөхцөлд ажиллаж буй нийт ажиллагсад хор саармагжуулах болон хамгаалалтын хувцас хэрэглэлээр хангах		Хүний тоо	10.000		5.000.000	Жилдээ	
3		Техникийн үзлэг оношлогоог мото цагийн дагуу тухай бүрт хийж бохирдуулагч хий үүсгэх нөхцөл бүрдхээс урьдчилан сэргийлэх	Тээврийн автомашин	Техникийн тоо ширхэг	Зардал тооцох боломжгүй	2	Зардал тооцох боломжгүй	Жилдээ	

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Цагаан-Овоо багийн нутаг дэвсгэрт орших “Ажилчдын хотхон-автобааз” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

4	Хөрс, ургамалд үзүүлэх сөрөг нөлөөлөл	Техникийн засвар үйлчилгээг хөрс бохирдуулахааргүй хамгаалсан тусгай талбайд явуулах	Кемпийн засварын талбай	М.кв тосгуур савны тоо ширхэг	-	-	Зардал тооцогдохгүй	Жилдээ	БОНБНУ-ний зөвлөмжийн дагуу
5	Амьтны аймагт нөлөөлөх нөлөөлөл	Барилга байгууламж барихаар төлөвлөсөн ухсан нүхэнд амьтан орж унахаас сэргийлж хаалт хашилттай, анхааруулах гэрэлтүүлэг тууз тавьж хамгаалах	Баригдаж буй объект орчимд	1объект/1 хэрэгсэл (тууз тэмдэг)	21000	10	210.000	Жилдээ	ХХАА-ны тухай
6	Усан орчны нөлөөлөл	Усны эх үүсвэрийн хамгаалалтын бүсийг дэглэмийг дагаж мөрдөж ажиллах	Кемпийн хэмжээнд	м	Урьдчилан зардал тооцох боломжгүй		Жилдээ	Усны тухай хууль	
7		Ус ашигласан төлбөрийг тухай бүр төлж ажиллах		ш	Урьдчилан зардал тооцох боломжгүй				Тухай бүр
	Нийт						5.210.000		

ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжүүлэгч нь “Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх” хуулийн Иргэн, аж ахуй нэгж, байгууллага эзэмшлийн болон өмчлөлийн газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу мод тарьж, зүлэгжүүлэх үүрэг хүлээнэ” гэсэн заалтын дагуу талбайн 10%-аас доошгүй талбай болох 1.5 га буюу 15000 м2-аас багагүй талбайд мод тарьж, зүлэгжүүлэх үүрэг хүлээнэ.

Тус төслийн ашиглаж буй 15 га талбайд газар ашиглалтын элэгдэл хорогдол цаашлаад экосистемийн бохирдол нөлөөллийг багасгах, ажилчдын амрах тав тух стресс ядаргааг бууруулах зорилгоор кемпийн барилгын ажил дууссаны дараа бид эзэмшил газрынхаа 10%-аас дээш талбайг ногоон байгууламжтай тэр дундаа говийн унаган модлог ургамал муркрофтын жигд, хайлаас гэх мэт ургамлыг тохижилтондоо тарихаар сонгож төлөвлөөд байна.

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд болон кемпийн ажилчдын ая тухыг хангах	Говийн унаган модлог ургамал тарих (Өмнөговь аймгийн БОАЖГ-ын 2023 оны 04-р сарын 04-ний өдрийн	Кемпийн хэмжээнд	ш	30	25.000	750.000	4-10 сар (усалгаа арчилгаа тогтмол хийх)	Тэрбум мод үндэсний хөтөлбөр

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Цагаан-Овоо багийн нутаг дэвсгэрт орших “Ажилчдын хотхон-автобааз” төслийн 2023 оны Байгаль
орчны менежментийн төлөвлөгөө

		зөвлөмж, чиглэл хүргүүлэх тухай албан бичгийн 7-р заалт)							
--	--	---	--	--	--	--	--	--	--

ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Археологи палентологийн тайлан БОНБНУ-нд туссанаар төсөл хэрэгжих талбайн орчимд түүх соёлын олдворын ул мөр байхгүй гэсэн дүгнэлт гарсан. Гэвч компаний хэмжээнд түүх соёл, археологийн олдвор олдсон тохиолдолд хэрхэн ажиллах үеийн журам зааврыг боловсруулан компаний удирдлагаар батлуулж нийт ажиллагсад шинээр тус компанид орж буй ажилтан бүрд зааварчилгаа мэдээллийг өгч ажиллана. Нийт ажиллагсадын нүдэнд ил харагдахуйц газарт түүх соёл археологийн олдворын тохиолдол илэрсэн үед мэдээлэх холбоо барих хүний утасны дугаар дотоод холбооны дугаарыг тодорхой бичиж хүлээх тухай агуулгатай хялбар зааварчилгааг байршуулна.

НАЙМ. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	
1	Шатах тослох материал хөрсөнд асгаралт өгөх хөрс бохирдох улмаар усан орчинд нөлөөлөх	Химийн бодис асгарсан, онцгой үед хэрэглэх багц, шингээгч материалыг зохих газруудад байрлуулах (Шатах тослох материалын болон хаягдлыг түр хадгалах цэгийг хөрс бохирдохоос хамгаалж бэлтгэх, асгаралтын иж бүрдлийг бэлэн байлгах) (Өмнөговь аймгийн БОАЖГ-ын 2023 оны 04-р сарын 04-ний өдрийн зөвлөмж, чиглэл хүргүүлэх тухай албан бичгийн 1-р заалт)	Кемпийн хэмжээнд	ш	Химийн бодисын шингээгч болон саармагжуулагч материалын дундаж үнэ	3.490.000	Жилийн турш	Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хууль

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Цагаан-Овоо багийн нутаг дэвсгэрт орших “Ажилчдын хотхон-автобааз” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2		ШТМ-н асгаралтын үед ажиллах үеийн зааварчилгааг нийт ажиллагсдад мөрдүүлэх	Нийт ажилчдад	-	-	-	ХХАА-ны зааварчилгаа тутамд	
3	Оршин суугчид байгаль орчны бүрдэл хэсгүүдэд хор хохирол учруулах	Нийт ажилчдад дотоод журманд тодорхой зааж танилцуулах	Нийт ажилчдад	-	-	-	Ээлжит болон шинэ ажилтны зааварчилгаа тутамд	
4	Гал түймэр болон газар хөдлөлт байгалийн гамшиг бусад осол аюулын үед хүн ам болоод байгаль орчныг сүйдлэх	ХХАА-ны зааварчилгаа, осол аюулын төлөвлөгөөнд тодорхой туссан ба нэгдсэн арга хэмжээ зааварчилгааг дагаж мөрдөн ажиллана.	Нийт оршин суугч, ажилчдад	-	Зардал тооцох боломжгүй		Тухай бүрт	Галын аюулгүй байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/, Гамшгаас хамгаалах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль
	Нийт					3.390.000		

ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Ахуйн	Нийт ажилчдаас гарч байгаа хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах, боловсруулах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Кемпийн хэмжээнд	Дахин ашигласан болон боловсруулсан хог хаягдлын хэмжэ	-	-	Жилийн турш	Хог хаягдлын тухай хууль, Хог хаягдлын улсын тоо бүртгэл хөтлөх, тайлагнах журам
2		Хог хаягдлын тоо бүртгэлээ тухай бүр хөтөлж, тогтоосон хугацаанд тайлагнах		Нэгж тайлан	-	-	Улирал бүр	
3		Хог хаягдлыг дахин боловсруулах, ашиглах үндэсний компаниудтай хамтран ажиллаж хаягдлын хэмжээг бууруулах (Өмнөговь аймгийн БОАЖГ-ын 2023 оны 04-р сарын 04-ний өдрийн зөвлөмж, чиглэл хүргүүлэх тухай албан бичгийн 2-р заалт)		тн	-	Гэрээнд заасан үнийн дүнгийн дагуу	Жилийн турш	

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Цагаан-Овоо багийн нутаг дэвсгэрт орших “Ажилчдын хотхон-автобааз” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

4		Гадаад талбайд хог хаягдлыг ангилан ялгаж хаях боломжтой хогийн савыг байрлуулах, хаягжуулах ажлыг үргэлжлүүлэх	Кемпийн хэмжээнд	ш	-	Урьдчилан тооцоолох боломжгүй	Жилийн турш	
5		Төслийн талбай болон түүний эргэн тойрны 300-500м-т бүх нийтийн цэвэрлэгээг үргэлжлүүлэн зохион байгуулах	Кемпийн хэмжээнд	га	5000	5.400.000	Сард 3 удаа	
6	Хатуу хог хаягдлыг ил задгай, зориулалтын бус цэгт хаях	Хог хаягдлын талаар нийт ажилчдад мэдээлэл түгээх, танилцуулга хийх (Өмнөговь аймгийн БОАЖГ-ын 2023 оны 04-р сарын 04-ний өдрийн зөвлөмж, чиглэл хүргүүлэх тухай албан бичгийн 3-р заалт)	Кемпийн хэмжээнд	Хүний тоо	-	-	Жилийн турш	Хог хаягдлын тухай хууль
7	Хүнсний хаягдал	Хоолны хаягдлаар компост бордоо бэлтгэх, бэлэн болсон бордоог мод тарилтанд ашиглах	Кемпийн хэмжээнд	тн	Урьдчилан тооцох боломжгүй		Жилийн турш	Хог хаягдлын тухай хууль, Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр
8	Ялаа шавж үржих, өвчин гарах	Хог хаягдлын цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг	Хог хаягдлын цэгт	-	-		Улирал бүр	Хог хаягдлын тухай хууль,

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Цагаан-Овоо багийн нутаг дэвсгэрт орших “Ажилчдын хотхон-автобааз” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

		тогтмол хийх, орчныг бохирдуулхаас сэргийлж ойр орчмыг тогтмол цэвэрлэж байх					
9	Аюултай хог хаягдал	“Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах” журмын хэрэгжилтийг хангаж ажиллах	Кемпийн хэмжээнд	тн	Урьдчилан тооцох боломжгүй	Жилийн турш	“Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах” журам
	Нийт				5.400.000		

АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах эрхзүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Усны хими физик, хүнд металлын шинжилгээг шинжлүүлэх	1	Улирал тутамд	Нэг цэгээс 1 удаа	124.600	514.400	Гэрээт лабораторид шинжлүүлнэ	MNS 0900:2018 Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Цагаан-Овоо багийн нутаг дэвсгэрт орших “Ажилчдын хотхон-автобааз” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2	Хөрсний найрлага хими физикийн шинж чанарыг шинжлүүлэх	1	Улирал тутамд	Нэг цэгээс 1 удаа	41.750	167.000	Гэрээт лабораторид шинжлүүлнэ	MNS 3298:1990 Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдөх хэмжээ
3	Орчны агаарын шинжилгээ	2	Жилд 2 удаа	-	2.200.000	4.400.000	Тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн компаниар хийлгүүлнэ	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
	Нийт					5.081.400		

АРВАННЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2023 он				
			Сар...	Сар...	Сар...		
	1	2	3	4	5	6	7
1	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах	-	2023 оны 1–р улиралд багтаан батлуулна.			Байгаль орчны мэргэжилтэн	
2	Кемпийн оршин суугч болон автобазын ажиллагсдад байгалийн ургамал талхлахгүй олон салаа зам үүсгэхгүй байх, шатах тослох	-	ХХАА-ны ээлжит болон шинэ ажилтны зааварчилгаа бүрт			Байгаль орчны мэргэжилтэн	

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Цагаан-Овоо багийн нутаг дэвсгэрт орших “Ажилчдын хотхон-автобааз” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

	материалын асгаралтын үед авах арга хэмжээний тухай болон бусад байгаль орчны холбогдолтой заавар зааварчилгаа, нийт ажиллагсдад ХХАА-ны ээлжит зааварчилгаагаар орох				
3	Цогтцэций сумын байгаль хамгаалагчтай хамтран биотехникийн арга хэмжээ авах	1.500.000	2023 оны 12-р сард	Байгаль орчны мэргэжилтэн	
4	Байгаль орчны тэмдэглэлт өдрөөр сумын байгаль хамгаалагч, ажилтнуудтай хамтран орон нутагт үйл ажиллагаа зохион байгуулах, (Өмнөговь аймгийн БОАЖГ-ын 2023 оны 04-р сарын 04-ний өдрийн зөвлөмж, чиглэл хүргүүлэх тухай албан бичгийн 4-р заалт)	1.000.000	2023 оны 3, 5, 6, 9-р саруудад	Байгаль орчны мэргэжилтэн	
5	Кемпийн хэмжээнд тамхи татах зориулалтын цэг байгуулах	3.000.000	2023 оны 2-р улиралд	Байгаль орчны мэргэжилтэн	
6	Ажилчдын хотхонд Байгаль орчны танин мэдэхүйн мэдээллийн самбар байрлуулах	2.000.000	2023 оны 3-р улиралд	Байгаль орчны мэргэжилтэн	
7	Сумын төвийн төвлөсөн хогийн цэгт мэргэжлийн байгууллагаар ТЭЗҮ хийлгэх (Өмнөговь аймгийн БОАЖГ-ын 2023 оны 04-р сарын 04-ний өдрийн зөвлөмж, чиглэл хүргүүлэх тухай албан бичгийн 6-р заалт)	Урдчилан тооцох боломжгүй	2023 оны 3-р улиралд	Компанийн удирдлагын төвшинд	
8	Сумын төвийн зорилтот бүлгүүийн айл өрхийн судалгаа хийх, утаагүй	Урдчилан тооцох боломжгүй	2023 оны 3-р улиралд	Компанийн удирдлагын төвшинд	

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Цагаан-Овоо багийн нутаг дэвсгэрт орших “Ажилчдын хотхон-автобааз” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

	цахилгаан халаагуурын хэрэглээг нэмэгдүүлэх боломж, судалгааг хийх (Өмнөговь аймгийн БОАЖГ-ын 2023 оны 04-р сарын 04-ний өдрийн зөвлөмж, чиглэл хүргүүлэх тухай албан бичгийн 5-р заалт)				
	Нийт	7.500.000			

АРВАНХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	Төрийн захиргааны төв байгууллагууд /Орон нутгийн БОАЖГ, бүх шатны Засаг дарга, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нар	Бичгээр хүргүүлэх, Хурал зохион байгуулах	БОМТ-ний хэрэгжилт	11 сарын 1-ны дотор	200.000	Төслийн удирдлага	БОАЖЯ-Тахилт хайрхан транс ХХК
2	БОАЖЯ-нд жилийн эцэст А/618 журмын дагуу орон нутгаас төлөвлөгөөний хэрэгжилтийн дүгнэлтийг авч хавсарган төлөвлөгөөний биелэлтийг хүргүүлнэ.	Бичгээр хүргүүлэх	БОМТ-ний хэрэгжилт	12 сард	-	Байгаль орчны мэргэжилтэн	БОАЖЯ-Тахилт хайрхан транс ХХК

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Цагаан-Овоо багийн нутаг дэвсгэрт орших “Ажилчдын хотхон-автобааз” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

3	Иргэд олон нийтэд хагас жил болон жилийн эцэст тайлангийн хурлыг автозам барих төсөлтэй хамт танилцуулах, иргэдийн саналыг авах	Хурал өдөрлөг зохион байгуулах	БОМТ-ний хэрэгжилт	9-10 сард	-	Байгаль орчны мэргэжилтэн	“Тахилт хайрхан транс” ХХК
	Нийт				200.000		

АРВАНГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ТӨСӨВ

Нийт 27 сая 531 мянга 400 төгрөгний зардал гарна гэж урьдчилан тооцсон ба уг тооцсон зардал нь байгаль орчныг хамгаалахад гарах шууд зардлаар тооцож байгаа ба зарим тохиолдолд хаягдлыг дахин ашиглана гэж үзсэн.

№	Байгаль орчны бүрдэлүүд	Зардал /сая.төг/
Тухайн жилийн нийт зардал		27.531.400
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	5.210.000
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	750.000
3	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	3.390.000
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	5.400.000
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	5.081.400
6	Тухайн жилийн байгаль орчны удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	7.500.000
7	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	200.000

